

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, **2024 оны 12 дугаар сарын 11-ний “Лхагва” гарагт** багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, ТЗУХ-ийн мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Нийслэлийн 2025 оны төсөв батлагдахтай холбогдуулан хөрөнгө оруулалтын ажлуудын эрхийг шилжүүлж, худалдан авах ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах.	СТСХ, ХААА
2	Он дуустал төсвийн орлого бүрдүүлэх ажлыг бүх шатандаа эрчимжүүлж ажиллах.	СТСХ, Татварын хэлтэс
3	Төсвийн зардлын хэмнэлтийг хэрэгжүүлж, төсвийн жилд өр, авлага үүсгэлгүй, төсвийг зориулалтын зүйлд зарцуулж, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулахад анхаарч ажиллах.	СТСХ, Татварын хэлтэс, Нийт байгууллагууд
4	Нийтийг хамарсан баярын арга хэмжээний үеийн хэв журмыг сахиулах, бэлэн байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.	Цагдаагийн хэлтэс, Нийт байгууллагууд
5	Хот нийтийн аж ахуйн нэн шаардлагатай байгаа машин, тусгай тоног төхөөрөмжийн жагсаалтыг гаргаж, танилцуулан, хүргүүлэх. (Хог тээврийн болон зам цэвэрлэгээний машиныг авах шаардлагатай талаарх саналыг 2024.12.04-ний өдрийн дотор)	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
6	БНХАУ-ын Харбин хотод ТҮК-иудын ажилчдыг сургалтанд хамруулах ажлын хүрээнд дүүргээс холбогдох ажилчдыг хамруулах талаар холбогдож, судалгааг хүргүүлэх.	ЗДТГ, Эрүүл мэндийн төв, Хангай сургууль
7	Нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, их дээд сургууль, албан байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудын хэмжээнд бэлгийн замын халварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, үзлэг зохион байгуулах эрх зүйн орчныг судалж танилцуулах.	
8	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтнуудыг ёс зүй, харилцааны богино хугацааны сургалтанд хамруулах.	ТЗУХ, Нийт байгууллагууд
9	Явган замын цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
10	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд мэдээллийн ил тод байдлыг хангаж, мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудсанд холбогдох хууль, журмын дагуу байршуулах ажлыг тогтмолжуулах хүрээнд нийслэл, дүүрэгт хийгдэж буй ажил, арга хэмжээ, бодлого шийдвэрүүдийг шуурхай түгээж ажиллах.	ТЗУХ, Нийт байгууллагууд
11	Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан хаагч, иргэдийг худалдан авах ажиллагааны АЗ	ХААА

	сургалтад хамруулж, сертификат олгох ажлыг зохион байгуулах.	
12	Аж ахуйн нэгж, байгууллагууд 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор орчноо чимэглэх, өнгө үзэмжээ сайжруулах, шинэ жилийн баярын уур амьсгал бүрдүүлэх ажлуудыг зохион байгуулах.	Нийт байгууллагууд
13	Дүүргийн нутаг дэвсгэрт шинэ жилийн баярыг 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах.	Холбогдох Ажлын хэсэг
14	2024 оны жилийн эцсийн тайлан мэдээ гаргах ажлын уялдаа холбоог сайжруулан, ААНБ болон ажилтан, албан хаагчдын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх ажлаа хугацаанд нь зохион байгуулах.	ЗДТГ, Нийт байгууллагууд
15	Шинэ жилийн баярыг тохиолдуулан хороодод Мөсөн хотхон байгуулах ажлын бэлтгэлийг сайтар ханган ажиллах.	Багахангай тохижилт, Багахангай Гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ууд
16	“Теле хяналтын камерын дэд төв”-ийн үйл ажиллагааг дуусган, ашиглалтад яаралтай оруулах ажлыг зохион байгуулах.	ЗДТГ, Цагдаагийн хэлтэс
17	Орон сууцны хорооллын болон нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн зорчих хэсгийн 1 дүгээр эгнээнд байрлуулсан тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгуулах, арга хэмжээ авах.	Цагдаагийн хэлтэс, Хороод, Нийт байгууллагууд
18	Ажлын байрны сахилга хариуцлагыг сайжруулан, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлж, хууль журмын хэрэгжилтийг ханган ажиллах.	Нийт байгууллагууд

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР